

“БЭРХ УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04-р сарын
30-ны өдөр

№01

Бэрх хот

Хаана: Хэнтий аймаг, Батноров сум, “Бэрх Уул” ХК-ийн төв оффисын байр

Эхэлсэн цаг: 09:00 цагт

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар компанийн гүйцэтгэх захирал А.Даваажав, хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Болд-Эрдэнэ, хурлын нарийн бичгийн дарга Б.Оюунчимэг, тооллогын комиссын дарга М.Батбилэг, тооллогын комиссын гишүүн Ж.Пүрэвдорж, Э.Ууганцэцэг, 4 хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар оролцов.

Тооллогын комиссын дарга М.Батбилэг “Бэрх Уул” ХК-ийн 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулав. Нийт 19’062’080 ширхэг хувьцаанаас нийтдээ 99.66% буюу 18’997’615.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид өөрийн биеэр оролцож хурлын ирц бүрдэж байгааг мэдэгдэж байна.

Хурлын ирц: 99.66 хувь

Хурлын дарга А.Даваажав: Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

1. Хурлын ирцийг бүртгэх
2. Хурлын ирцийг мэдээлэх
3. Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
4. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах
5. Хурлын завсарлага
6. Тооллогын комиссын тогтоолын дүнг танилцуулах
7. Хурлыг хаах

Хурлын дарга компанийн гүйцэтгэх захирал А.Даваажав хуралд оролцогч талуудтай мэндчилж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2026 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг хэлэлцэн батлах
3. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох

5. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

6. Зээл, өр төлбөрийн талар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж батлах

Хурлын дарга А.Даваажав: 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Хурлын дарга А.Даваажав Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж аудитын дүгнэлтийг хэлэлцүүлэв.

“Бэрх Уул” ХК нь Чандган тал MV-04590А талбайгаас нүүрс олборлон дотоодод буюу Хэнтий аймаг, сумдын хэрэглэгчдийг халаалтын улиралд нүүрсээр ханган ажиллаж байна.

Компанийн 2025 оны жилийн орлогын тайлан нь дараах байдалтай байна.

№	Төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он
			Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
	Бүтээгдэхүүн олборлолт, борлуулалт				
1	Нүүрс	тн	49,190	38,480.0	49,190
	Борлуулалтын орлого - нийт		1,538,436	1,795,203	2,486,683
2	Нүүрс	мян.төг	2,213,550	1,408,982	2,475,733
4	Бусад / Түрээс /	мян.төг	4,364	-	10,950
5	Бусад	мян.төг	250,000	386,221	200,000
	Нийт зардлын дүн	мян.төг	1,540,331	1,736,617	2,246,894
5	Чандган	мян.төг	1,425,409	991,794	1,425,409
6	Захиргаа	мян.төг	806,627	640,103	648,185
7	Харуул	мян.төг	130,600	103,887	169,150
9	ТУЗ-ийн зардал	мян.төг	5,500	832	4,150
	Ашиг алдагдал -нийт	мян.төг	6,500,222)	(998,557)	239,789
10	Чандган	мян.төг	788,141	417,188	1,050,324
11	Захиргаа	мян.төг	(552,263)	(253,882)	(637,235)
12	Харуул	мян.төг	(130,600)	(103,887)	(169,150)
14	ТУЗ	мян.төг	(5,500)	(832)	(4,150)
15	Зээлийн хүүгийн зардал	мян.төг	1,500,000)		
16	Валютын ханшын зөрүү ашиг /алдагдал/	мян.төг	(5,100,000)	(1,057,143.5)	

Санхүү байдлын тайлан 2025

№	Хураангуй баланс	Хэмжих нэгж	2024 он	2025 он
1	ХӨРӨНГӨ:			
2	Эргэлтийн хөрөнгө	Сая.төг	1,148.52	1,109.27
3	Эргэлтийн бус хөрөнгө	Сая.төг	6,404.72	6,337.45
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	Сая.төг	7,553.25	7,446.73
5	ӨР ТӨЛБӨР:			
6	Богино хугацаат өр төлбөр	Сая.төг	22,784.88	23,143.95
7	Урт хугацаат өр төлбөр	Сая.төг	8,107.24	8,228.94
8	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:	Сая.төг	35,898.70	36,790.74
9	ЭЗДИЙН ӨМЧ			
10	Хувийн өмч	Сая.төг	1,906.21	1,906.21
11	Дахин үнэлгээний нэмэгдэл	Сая.төг	1,990.68	1,990.68
12	Хуримтлагдсан ашиг	Сая.төг	(32,242.34)	(33,240.90)
13	ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН			
14	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	Сая.төг	7,553.25	7,446.73

Компани нь санхүүгийн тайлан баланс, болон аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны албан татвар, агаарын бохирдлын албан татвар мөн нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь тогтмол гаргаж тайлагнадаг.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хуульд заагдсан суутгал, төлбөр:

№	Татвар болон хуульд заагдсан суутгал, төлбөр /мян.төг/	2022	2023	2024	2025
1	Газрын төлбөр-Дэд алба	22.91	24,473.33	2,354.33	3,896.01
2	Ус бохирдуулсны төлбөр	-	-	750.00	1,501.00
3	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	589.78	615.00	-	-
4	Нүүрсний агаарын бохирдлын төлбөр	26,124.88	5,257.23	7,238.19	27,641.06
5	Автын агаарын бохирдлын төлбөр	143.20	-	9.50	-
6	Татварын торгууль	-	1,300.00	122,810.00	25,890.00
7	Галт зэвсгийн албан татвар	32.00	120.00	120.00	120.00
8	Дотоодын бараа, үйлчилгээний суутгасан НӨАТ	192,636.79	82,385.07	51,397.83	33,069.69
9	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,697.85	-	99.40	-
10	АМНАТ-Тусгай зөвшөөрөл эзэмшигч	45,236.94	21,587.90	2,146.43	28,489.09
11	Газрын төлбөр	152.91	-	-	-

12	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	-	-	50.00	12,412.98
13	Зам ашигласны төлбөр	30.00	-	10.00	-
14	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар	4,338.96	45,160.31	21,741.22	29,185.78
15	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	36,908.43	11,552.16	-
16	Хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8,090.34	8,090.34	4,046.64	11,108.62
17	Татварын алданги	-	12,972.19	-	-
18	Суутгагчийн хуулийн этгээдэд олгосон орлогоос суутгасан татвар	-	-	-	1,001.00
19	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт	74,272.90	96,127.94	83,239.10	50,252.05
	ДҮН	353,369.46	334,997.73	307,564.80	224,567.28

Чандганы хэсэг

ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Чандган талын хүрэн нүүрсний орд нь Нялгын нүүрсний сав газрын зүүн хойд хэсэгт Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Шорвогийн тал хэмээх газарт оршдог. Улаанбаатар хотоос 290км-т зүүн чиглэлийн мянганы замаас урагш 5км Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотоос баруун хойш 54 км зайд байрладаг.

Тус орд нь дэд бүтцийн хувьд зам харилцаа, цахилгаан холбоо хөгжсөн, хүн ам суурьшсан төв суурин газруудтай ойрхон, эдийн засгийн харьцангуй тааламжтай нөхцөлд оршдог. Газрын гадаргуугын усан сүлжээний хувьд байнгын урсгал ус байхгүй, тогтмол нуур, цөөрөмтэй. Энд тогтсон нуурууд нь хур тунадасны усаар тэжээгддэг давстай нуурууд байдаг. Орд нь зүүн хойноос баруун урагш сунасан 1400-1500м өндөртэй уул нуруугаар хязгаарлагдсан уулс хоорондын далайн түвшнээс 1150-1188м-т өргөгдсөн хөндийд байрлана. Газрын гадаргын хувьд жижиг дов, толгод зонхилсон хотгор, гүдгэртэй тал хээрийн бүсийн шинжтэй гадаргуутай. Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, зун нь харьцангуй дулаахан, 15-35 хэм хүртэл халах ба бороо хурын үед сэрүүвтэр байна. Өвөл нь 25-37 хэм хүйтэн, эхний цас 10-р сарын эхээр орно. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 350мм бөгөөд үүний ихэнх нь 6-8 дугаар сарын хооронд ордог. Салхины чиглэл голлон зүүн хойноос баруун ургах чиглэлтэй 20 м.с хүртэл хурдтай байна. Орон нутгийн хүн ам ихэнхи нь мал аж ахуй болон газар тариалан эрхлэн үр тариа, хүнсний ногоо тарьж орон нутгийн хэрэгцээг хангана.

Чандганы нүүрсний уурхайг ЗГ-ийн 1999 оны 05-р сарын 02-ны өдрийн 74 тоот тогттолын дагуу “Бэрх Уул” ХК-ийн бүрэлдэхүүнд нэгтгэсэнээс хойш өнөөдрийг хүртэл хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг явуулж Хэнтий аймгийн төв болон зарим сумдыг нүүрсээр ханган тасралтгүй ажиллаж ирсэн.

Тус уурхайн олборлолтын хэмжээ нь Хэнтий аймаг болон бусад сумдын хэрэглэгчийн жилийн хэрэгцээнээс шууд хамааралтай.

Чандганы хэсгийн 2025 оны борлуулалт үйл ажиллагаа

Чандганы нүүрсний уурхай нь орон нутгийн чанартай нүүрсний уурхай тул дотоодод буюу Хэнтий аймгийн төвийн болон бусад сумдын аж ахуй нэгж, хувь хүмүүст жилийн 1-4, 10-12-р саруудад нүүрс олборлон борлуулдаг. 2025 онд төвлөрсөн халаалтын зуухнууд болон үйлдвэр аж ахуйн газарт 38,480 тн нүүрсийг олборлон борлуулсан.

№	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Нүүрсний борлуулалт	тн	38,480
2	Нүүрсний борлуулалт	/сая.төг/	1,408,982

Хөрс хуулалт

“Бэрх Уул” ХК-ийн Чандганы нүүрсний уурхайн хэсэг нь хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан техник шинэчлэлт хийж чадаагүй, мөн уул геологийн нөхцөл хүндэрсэн зэргээс шалтгаалан сүүлийн 2015-2020 онд иргэн, аж ахуй нэгжээс техник тоног төхөөрөмж түрээслэж хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байсан.

2025 оны 8-р сарын 01-ний өдрөөс хөрс хуулалтын ажлыг эхлүүлж 39,086.15м.куб гаргасан байна.

Техник тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ

Тус уурхай нь дараах техникүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: KOMATSU-D155A, KOMATSU -D65A /Бульдозерууд/ DOOSAN эксковатор, /300.500/ ZL50C-автоачигч 2 ширхэг Ланд Крусер 78-1 ширхэг Запрушка-1 ширхэг Автосамасвол-2 ширхэг Зэрэг техникүүдээр 2025 онд уурхайн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Автоачигч, бульдозер, эксковатор зэрэг техникүүдийн ашиглалтын хугацаа дууссан, явах эд анги болон бусад эд анги муудсан зэргээс шалтгаалан техник эвдэрч байсан бөгөөд дараах засвар үйлчилгээг хийсэн Техник тус бүр дээр дараах зардлууд гарсан байна. Уурхайн дэд бүтэц, тохижилт, туслах аж ахуйн хүрээнд

- 2025 оны 02-р сард Хэнтий аймгийн халажийн төвд 92тн нүүрс хандивласан
- Засварын багаж, тоног төхөөрөмж хийх, хадгалах байрны засварын ажлыг
- “Бэрх Уул” ХК-ийн ажилчид тус бүрт 3тн, Батноров сумын ЗДТГ-т 26,3тн нүүрс тус тус хандивласан.
- Ажилчдын хоол хүнсэнд төмс, манжин, лууван, сонгино тарьсан,
- 2025 оны 10-р сард Хэнтий аймгийн Мөрөн сумд 18тн нүүрс хандивласан
- Хэнтий аймгийн Мөрөн сумын уурхайн нутаг дэвсгэрт байдаг малчдад нийт 47тн нүүрс хандивласан

“Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгаа”-г байгууллагын онцлогт тохируулан боловсруулж мөрдөн, ажилчдад ХХАА-ны дүрэм журмыг тогтмол өгч, гарын үсгээр баталгаажуулан ажилладаг.

Хүний нөөц, боловсон хүчин

2025 онд тус компани нь Захиргааны хэсэгт-8 ажилчин, Чандганы нүүрсний уурхайн хэсэгт-14 ажилчин, Харуулын албаны хэсэгт-13 ажилчин гэсэн

бүрэлдэхүүнтэйгээр, нийт 35 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс эмэгтэй-10, эрэгтэй-25 ажилчидтай.

Тус компани нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан үйл ажиллагаанд мөрдлөг болгож, 2 жил тутам шинэчилдэг. Ажил олгогчийн зүгээс ажилтан бүртэй Хөдөлмөрийн гэрээ байгуулж, шинээр орсон ажилтантай 3 сар хүртэл туршилтын гэрээ байгуулан ажиллуулдаг. Мөн ажиллагсдын цалинг сар бүрийн сүүлийн 7 хоногт олгож, нийгмийн даатгалын дэвтэрт үнэн зөв бичилт хийн баталгаажуулж ирлээ.

“Бэрх Уул” ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ “Бэрх хотын угтах хаалганы ойролцоо тохижилтын ажлыг хийв. Угталтын хаалганы ойр орчимд нарны зайн тэжээлийн үүсгүүрт гэрэлтүүлэг хийсэн.
- ✓ “Бэрх Уул” ХК-ийн төв оффист босоо душ, суултуур, угаалтуур суурилуулан ариун цэврийн өрөөг шинэчлэн засварлаж тохижуулав.
- ✓ Бэрх хотын захиргааны барилгын урд талбайд уурхайчин гэр бүл ба зөвлөлтийн инженерийн баримлыг хийлгэж, Бэрх хотын захирагчийн хамт нээлт хийж, хүлээлгэн өгөв.
- ✓ “Бэрх Уул” ХК-ийн төв оффисын урд талбайд хүндэтгэлийн гэрийн урд талбайд чулуу суулган засаж өөрчлөв.
- ✓ Хэнтий аймгийн Батноров суманд зохион байгуулагдсан марафон тэмцээний үеэр 2000 ширхэг цэвэр ус хандивлаж, сумын иргэдийн спортын тэцээнийг дэмжиж буйгаа илэрхийлэв.
- ✓ “Чандганы уурхайн хэсэгт техник шинэчлэлт хийсэн. Чандганы хэсэгт ажилчидын хүнсний ногоо тариалж өөрсдийн хэрэгцээг хангасан.
- ✓ Малын тэжээлд царгас, ажилчдын амжиргаанд чацарганы мод тариж нутагшуулж байнгын арчилгаа усалгаа хийж байна.
- ✓ Хэнтий аймгийн мөрөн суманд нийтийн бие засах газар хийж байрлуулж өгсөн.
- ✓ Чандганд шинээр ХХАБ өрөө байгуулан тохижуулсан. Аюулгүй байдал, харуул хамгаалалтандаа анхааран бүрэн камержуулсан
- ✓ Нийгмийн хариуцлагын хүрээнд Тэмдэглэлт баярын өдрүүд, шуурхай гэнэтийн үйл явдлыг тохиолдуулан Бэрх хотын захирагчийн албатай хамтран ажиллах, арга хэмжээнүүдийг зохион байгуулах, хандив зэргээр олон нийтийн оролцоог ханган ажиллав.
- ✓ “Бэрх Уул” ХК-ын ажилчид байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцож, ойн сан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр Мөрөн сумын Чандгана багт байрлах Чандганы уурхайд мод тарих ажилд идэвхитэй оролцож байна.
- ✓ Эх үрсийн баяраар бяцхан үрсдээ бэлэг бэлдэж баярлуулах үйл ажиллагаа уламжлал болсон байна.

- ✓ Нийгмийн хариуцлагын хүрээнд Ардын хувьсгалын 106 жилийн ой, Батноров сумын үндэсний их баяр наадмын үйл ажиллагаанд хандив өгөв.
 - ✓ 2025.07.11 Үндэсний сурын харвааны нээлттэй тэмцээнийг "Бэрх уул" ХК-ийн нэрэмжит болгон ивээн тэтгэж, цаашид уламжлал болгон зохион байгуулахаар боллоо.
 - ✓ Ахмадын баярын үеэр азын сугалаа явуулж, ахмадуудаа баярлуулав. Ахмадын баяраар Бэрх-Уул ХК-ийн 105 ахмад настанд 100'000 төгрөг өгч, хүндэтгэл үзүүлэв.
2. Гүйцэтгэх захирал А.Даваажав 2026 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө болон орлого зардлын төлөвлөгөөг танилцуулав.

" БЭРХ УУЛ " ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2026 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он
			Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
	Бүтээгдэхүүн олборлолт, борлуулалт				
1	Нүүрс	тн	49,190	38,480.0	49,190
	Борлуулалтын орлого - нийт		1,538,436	1,795,203	2,486,683
2	Нүүрс	мян.төг	2,213,550	1,408,982	2,475,733
4	Бусад / Түрээс /	мян.төг	4,364	-	10,950
5	Бусад	мян.төг	250,000	386,221	200,000
	Нийт зардлын дүн	мян.төг	1,540,331	1,736,617	2,246,894
5	Чандган	мян.төг	1,425,409	991,794	1,425,409
6	Захиргаа	мян.төг	806,627	640,103	648,185
7	Харуул	мян.төг	130,600	103,887	169,150
9	ТУЗ-ийн зардал	мян.төг	5,500	832	4,150
	Ашиг алдагдал -нийт	мян.төг	6,500,222)	(998,557)	239,789
10	Чандган	мян.төг	788,141	417,188	1,050,324
11	Захиргаа	мян.төг	(552,263)	(253,882)	(637,235)
12	Харуул	мян.төг	(130,600)	(103,887)	(169,150)
14	ТУЗ	мян.төг	(5,500)	(832)	(4,150)
15	Зээлийн хүүгийн зардал	мян.төг	(1,500,000)		
16	Валютын ханшны зөрүү ашиг /алдагдал/	мян.төг	(5,100,000)	(1,057,143.5)	

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он
			Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
1	ТУЗ-н даргын цалин	мян.төг			
2	ТУЗ-н даргын түлшний зардал	мян.төг	7,500	-	2500
3	ТУЗ-н гишүүдийн цалин	мян.төг			
4	ТУЗ-н нарийн бичгийн цалин	мян.төг			

5	Хурлын материал орчуулгын зардал	мян.төг	300		300
6	ТУЗ-н бичиг хэргийн зардал	мян.төг	100		100
7	ТУЗ-н даргын томилолтын зардал	мян.төг			
8	ТУЗ-н хурлын зардал	мян.төг	250		250
9	ТУЗ-н НДШимтгэл	мян.төг			
10	Удирдлагын бусад /Утас, сэлбэг, бусад/	мян.төг	6,960	832	1,000
Нийт зардлын дүн		мян.төг	5,500	832	4,150

ЗАХИРГАА АЖ АХУЙН ХЭСГИЙН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он
			Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
1	Борлуулалтын орлого - нийт	мян.төг	260,950	386,221	10,950
1	Бусад орлого	мян.төг	250,000	386,221	200,000
2	Түрээсийн орлого	мян.төг	10,950		10,950
	Нийт зардлын дүн	мян.төг	806,627	640,103	648,185
1	Цалингийн зардал	мян.төг	360,000	237,324	290,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	50,400	30,189	40,600
3	Албан томилолтын зардал	мян.төг		14,573	50,000
4	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	5,000	1,284	5,000
5	Элэгдлийн зардал	мян.төг	72,000	22,893	72,000
6	Шатахуун тос	мян.төг	65,000	42,745	25,000
7	Бичиг хэргийн зардал	мян.төг	3,500	2,289	2,500
8	Шуудан холбоо	мян.төг	3,000	2,866	3,000
9	Программ хангамж	мян.төг	1,522		2,000
10	Сэлбэг хэрэгслийн зардал	мян.төг	20,000	16,988	20,000
11	Байрны урсгал засвар	мян.төг	35,000	3,604	50,000
12	Цахилгааны зардал	мян.төг	3,500	12,669	2,000
13	Халаалт дулааны зардал	мян.төг	55,000	79,514	15,000
14	Лицензийн төлбөр / 10965А /	мян.төг	842		842
15	Лицензтэй холбоотой бусад	мян.төг	-		
16	АТБӨЯХАТатвар	мян.төг	-	221	
17	Бууны татвар	мян.төг	120	120	120
18	ҮХХАТатвар	мян.төг	-	8,090	9,000
19	Газрын төлбөр	мян.төг	323	1,096	323
20	Геологи хайгуул судалгааны ажлын зардал	мян.төг	-		
21	Аудит, үнэлгээний зардал	мян.төг	10,000	4,041	10,000
22	Хуулийн зөвлөх үйлчилгээ	мян.төг	-		
23	МХБиржийн бүртгэлийн хураамж	мян.төг	1,800	1,552	1,800
24	Бусад/буцалтгүй тусламж/	мян.төг	2,000	10,279	3,000
25	Банкны шимтгэл	мян.төг	1,000	725	1,000
26	Хог хаягдлын төлбөр	мян.төг	120		

27	Хангамжийн материал	мян.төг	1,500	5,284	
28	Ажилчдын сургалтын зардал	мян.төг		350	
29	Хандив, Спортын арга хэмжээ, Еслол хүндэтгэлийн арга хэмжээ	мян.төг	55,000	41,563	25,000
30	Бусад зардал	мян.төг	60,000	99,846	20,000

ЧАНДГАНЫ ХЭСГИЙН 2026 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он
			Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
1	Бүтээгдэхүүн олборлолт				
1	Нүүрс	тн	49,190.00	38,480.0	49,190
2	Борлуулалтын орлого - нийт	мян.төг	2,213,550	1,408,982	2,475,733
1	Нүүрс	мян.төг	2,213,550	1,408,982	2,475,733
3	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - нийт	мян.төг	1,425,409	991,794	1,425,409
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг	295,000	77,648	295,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	42,775	9,950	42,775
3	Албан томилолтын зардал	мян.төг	1,000	1,405	1,000
4	Хүнсний зардал	мян.төг	30,000	50,907	30,000
5	ХХААжиллагааны зардал	мян.төг	10,000	18,338	10,000
6	Шатахуун тосны зардал	мян.төг	350,000	334,607	350,000
7	Техникийн түрээсийн зардал	мян.төг	35,000	9,296	35,000
8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг	40,000	73,066	40,000
9	Сэлбэг материал	мян.төг	90,000	86,731	90,000
10	Байрны урсгал засвар	мян.төг	35,000	754	35,000
11	Цахилгаан	мян.төг	300,000	115,505	300,000
12	Лицензийн төлбөр /4590 А /	мян.төг	-		
13	АМНАТөлбөр	мян.төг	55,339	35,827	55,339
14	Зээлийн хүүгийн зардал	мян.төг	55,000	102,776	55,000
15	Газрын төлбөр	мян.төг	2,700	2,800	2,700
16	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	мян.төг	24,595	19,223	24,595
17	Геологи, судалгааны ажлын зардал	мян.төг	15,000	13,913	15,000
18	Нөхөн сэргээлийн зардал	мян.төг	5,000		5,000
19	Тээврийн зардал	мян.төг		14,671	
20	Бичиг хэргийн зардал	мян.төг	1,000	1,706	1,000
21	Шуудан холбооны зардал	мян.төг	3,000	5,027	3,000
22	Хангамжийн материалын зардал	мян.төг	2,000	14,000	2,000
23	Хог хаягдлын төлбөр	мян.төг	3,000	2,700	3,000
24	Ногоо, тэжээл тарих	мян.төг	-		
25	Бусад зардал	мян.төг	30,000	945	30,000

№	Ашиг алдагдал -нийт	хэмжих нэгж	2025		2026 төсөв
			Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
1	Борлуулалт	мян.төг	2,213,550	1,408,982	2,475,733
2	ББӨ	мян.төг	1,425,409	991,794	1,425,409
3	Нийт ашиг	мян.төг	788,141	417,188	1,050,324

3. Компанийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг сунгаж

1. Ердийн гишүүнд:

- Раднаагийн Бадрах
- Амарсайханы Даваажав
- Бадрахын Наранзаяа
- Бат-Очирын Аригуун
- Батжаргалын Баярцэнгэл
- Өлзийбүрэнгийн Алдарбаяр нарыг

Хараат бус гишүүнд:

- Ёндонгийн Амарбат
 - Дансрангийн Энхболд
 - Лувсанчүлтэмийн Тэмүүжин нарыг хэлэлцүүлэн шийдвэрлэв.
4. Компани 2025 оны санхүүгийн тайлантай танилцаж хувь нийлүүлэгчдэд 2025 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ-ийн шийдвэрлэснийг танилцуулж батлав.
5. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээтэй холбоотой ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулж хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.
6. Зээл, өр төлбөрийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлж шийдвэрлэв.

Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга М.Батбилэг хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулав.


1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн талаарх аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. 2026 оны ажлын төлөвлөгөөг, зардлын төсвийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
3. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
4. Компанийн шинэ ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдээс Р.Бадрах 16.7%, Б.Наранзаяа 16.7%, А.Даваажав 16.7%, Б.Аригуун 16.7%, Б.Баярцэнгэл 16.7%, Ө.Алдарбаяр 16.7%, тус тус саналтайгаар ердийн гишүүнээр сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд Л.Тэмүүжин 33.3%, Ё.Амарбат 33.3%, Д.Энхболд 33.3% саналтайгаар тус тус хараат бус гишүүдээр сонгогдлоо.

5. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
6. Зээл, өр төлбөрийн талаар ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.

Хурал:11:40 өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хянасан хурлын дарга:  /А.Даваажав/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  /Б.Оюунчимэг/

2026 оны 04-р сарын 30-ны өдөр

Бэрх хот